

**ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-7

1. Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/	3-5
2. Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Ёс зүй, дэгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	5-7

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Ёс зүй, дэгийн байнгын хорооны 10 дугаар сарын 15-ны
өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны
товч тэмдэглэл**

Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 13 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 53.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 07 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Х.Баасанжаргал, Б.Жавхлан;
Тасалсан: Ж.Батсуурь, Д.Жаргалсайхан, Г.Очирбат.

Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Баярбаатар төслийн талаар танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл үг хэлэв.

Б.Баярбаатар: “Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэх гишүүний чуулганы ажиллагаанд оролцох журмын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 0
Бүгд: 8
100 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

“Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэх гишүүний чуулганы ажиллагаанд оролцох журмын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Б.Жавхлан, Г.Очирбат, Д.Энхтуяа нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Ёс зүй, дэгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Баярбаатар төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Баярбаатар: “Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Ёс зүй, дэгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 2
Бүгд: 8
75.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяаг дэмжсэнээр тооцож, 87.5 хувийн саналаар батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны дарга Б.Баярбаатар Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нарад холбогдох Үндсэн хуулийн цэцийн 2024.10.09-ний өдрийн 2/488 дугаар бүхий албан бичгийг танилцуулав.

Мөн Ёс зүй, дэгийн байнгын хорооны тогтоолоор Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нарад Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм зөрчсөн гэж хариуцлага ногдуулсан тухай протоколд тэмдэглүүлэв.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 14 минут үргэлжилж, 13 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 61.5 хувийн ирцтэйгээр 15 цаг 21 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БАЯРБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их засаг” танхим,
15 цаг 07 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хорооны гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Хурлын ирц танилцуулна. Баярмагнай овогтой Баярбаатар ирсэн байна. Аюушийн Ариунзаяа гишүүн ирсэн байна. Дуламын Бум-Очир гишүүн ирсэн байна. Даваасамбуугийн Ганмаа гишүүн ирсэн байна. Болдын Жавхлан гишүүн чөлөө авсан. Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн ирсэн байна. Дүгэрийн Рэгдэл гишүүн ирсэн байна. Бадарчийн Хэрлэн гишүүн ирсэн байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн замд яваа, үл ялиг бас жоохон хоцорч орж ирэх тухайгаа мэдэгдсэн.

Ирц 53,8 болсон учраас Мягмар гарагийн Ёс зүйн дэгийн байнгын хорооны хуралдаан нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудал танилцуулна.

1. “Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэх гишүүний чуулганы үйл ажиллагаанд оролцох журмын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл танилцуулна.

2. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Ёс зүй, дэгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” гэсэн 2 асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт саналтай гишүүд байна уу?

Байхгүй бол хэлэлцэх асуудалдаа оръё.

Өнгөрсөн хугацаанд бид 24 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Байнгын хорооны хийх ажлын төлөвлөгөөг Байнгын хорооны гишүүдээсээ санал авсны үндсэн дээр баталсан.

Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу шийдвэрийн төслүүдийг боловсруулах, хэлэлцүүлэх, бэлтгэх чиглэлээр 10, хянан шалгах үйл ажиллагааны чиглэлээр 5, уулзалт хэлэлцүүлэх, сурталчилгааны чиглэлээр 7 гээд нийтдээ ингээд 22 ажил хийхээр төлөвлөсөн байгаа.

Хууль, эрх зүйн орчинд үнэлгээ хийх, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий 54 ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан. Үүнд манай Байнгын хорооноос ажиллаж байгаа Улсын Их Хурлын гишүүд ажлын хэсэгтээ ороод ажиллаад явна.

Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23.5.6-д заасан Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэх гишүүний чуулганы ажиллагаанд оролцох журмын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах ёстой. Тус ажлын хэсгийг би та бүхэнд өчигдөр материалаар тараагдсан. Тэгэхдээ өнөөдөр би ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг уншаад, төсөл танилцуулья.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.5.6 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Ёс зүй, дэгийн байнгын хорооноос тогтоох нь:

Нэг. Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэх

гишүүний чуулганы ажиллагаанд оролцох журмын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

1. Ажлын хэсгийн ахлагч Аюушийн Ариунзаяа Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүд Ж.Батсуурь Улсын Их Хурлын гишүүн, Б.Жавхлан Улсын Их Хурлын гишүүн, Г.Очирбат Улсын Их Хурлын гишүүн, Д.Энхтуяа Улсын Их Хурлын гишүүн, Д.Наранцэцэг Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх, Ж.Бямбадулам, Хууль зүй, дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх, нарийн бичгийн даргаар О.Мөнгөнчавхдас Ёс зүй дэгийн байнгын хорооны ажлын албаны референт.

Хоёр. Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэх гишүүний чуулганы ажиллагаанд оролцох журмын төслийг 2024 оны 12 сарын 15-ны дотор боловсруулж, Байнгын хороонд танилцуулахыг ажлын хэсэг А.Ариунзаяад даалгасугай гэсэн ийм 2 заалт бүхий Байнгын хорооны тогтоолын төслийг танилцууллаа.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Асуулт асуух гишүүд алга байна.

Санал буюу үг хэлэх гишүүд байна уу? Рэгдэл гишүүнээр тасалъя. Рэгдэл гишүүн.

Д.Рэгдэл: Зүгээр редакцын л чанартай л юм. Энэ заалт дээр 1 дүгээр заалт, 2 дугаар заалт дээр зүгээр Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэх, ингэжхээд Улсын Их Хурлын гишүүн гэвэл зүгээр байх. Улсын Их Хурлын гишүүн, гишүүний биш, гишүүн чуулганы ажиллагаанд оролцох журам гээд тавьчихвал Монголоор, хэлээр арай цэвэр дуудах юм шиг байна лээ.

2 дугаар заалт дээр бас гишүүний гэдгийн гүйцэтгэх гишүүн чуулганы ажиллагаа гээд редакцын чанартайг ялихгүй л гэсэн үг гэж байгаа юм шиг л байна шүү дээ.

Б.Баярбаатар: Рэгдэл гишүүний санал дээр ийм байна. Уул нь бол яг тантай би санал нэг байна. Тэгэхдээ Их Хурлын тухай хуулийн 23.5.6 дээр Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэх гишүүний чуулганы ажиллагаанд оролцох журмын асуудал гэж. Нөгөө хууль дээр тусчихсан хэллэг нь ийм байгаа байхгүй юу. Тийм. Хуулийн хэллэг.

Тэгэхээр энэ нөгөө бид нар өөрсдөө ингээд биччихсэн зүйл биш учраас нөгөө хуулийн хэллэгээр нь. Хэрвээ бид нар таны саналаар өөрчилье гэвэл Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулж байж, дараагийн асуудал руу ярих ийм нөхцөл байдал руу орж байгаа.

Энхтуяа гишүүн суучих даа? Тийм. Энхтуяа гишүүн орж ирсэн учраас би бас мэдээллийг дахиад хэлчихье гэж бодож байна. Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэх гишүүний чуулганы ажиллагаанд оролцох журмын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооноос тогтоолоор байгуулж байна. Ажлын хэсгийн даргаар Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа, гишүүдэд Ж.Батсуурь, Б.Жавхлан, Г.Очирбат, Д.Энхтуяа гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг байгуулж байгаа шүү, Энхтуяа гишүүн ээ. Танд мэдээлэл болгоод өгөхөд ийм ажлын хэсэгт орж байна.

Ингээд асуулт асууж, санал хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны тогтоолыг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.

8 гишүүн зөвшөөрч 100 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн журмын төслийг үр дүнтэй боловсруулаад, холбогдох Монгол Улсын Ерөнхий сайд, Ерөнхий сайдын ажлын алба, ЗГХЭГ-аас холбогдох саналуудыг авч журмын төсөлдөө тусгах нь бол зөв байх.

Дээр нь ажлын хэсгийг ахалж байгаа Ариунзаяа Улсын Их Хурлын гишүүн маань өмнө нь Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдаар ажиллаж байсан туршлагатай байгаа учраас би ажлын хэсэг ахлууллаа.

Мөн Байнгын хороонд орж ажиллаж байгаа манай Болдын Жавхлан Сангийн сайд маань өнөөдөр Засгийн газрын гишүүний үүргийг бас хавсран гүйцэтгэж байгаа учраас ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан. Ажлын хэсэг бол хэн, Батсуурь гишүүн, 2 сайд орсон учраас бас журам бол нэлээн чамбай зүйл орж ирэх байх гэж Байнгын хорооны даргын хувьд найдаж байна.

15.14 цаг

Дараагийн асуудалдаа орёё.

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Ёс зүй, дэгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны төслийг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэгт ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлыг баталсан Улсын Их Хурлын тогтоолд заасан хууль тогтоолын төслийн хэлэлцэх дарааллын зөвлөлийн санал өргөн мэдүүлсэн дарааллыг харгалзан Улсын Их Хурлын дарга сар бүр захирамжаар батална гэж, мөн зүйлийн 5.6-д энэ хуулийн 5.5-д заасан дарааллын үндэслэн хэлэлцэх асуудлын цаглаврыг

Байнгын хороод баталж мөрдүүлнэ гэж тус тус заасан байгаа.

Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхнийг тараасан байгаа учраас би уншихыг түр азная.

Тогтоолын төсөл цаглавартай холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Асуулт алга байна.

Санал хэлэх гишүүд байна уу? Санал тасаллаа. Санал алга байна.

Би тогтоолын төслийг уншиж танилцуулна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Ёс зүй, дэгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсгийг үндэслэн Байнгын хорооноос тогтоох нь:

1. Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай 163 дугаар захирамжид тусгагдсан Ёс зүй, дэгийн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх цаглаврыг хавсралтаар баталсугай.

2. Хэлэлцэх хугацааг хуульд тусгайлан заасан болон бусад Байнгын хорооны эрх асуудлын хүрээнд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Ёс зүй, дэгийн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхэд энэ цаглавар хамаарахгүй.

3.Энэ тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Ёс зүй, дэгийн Байнгын хорооны дарга Баярбаатарт, хэлэлцэх асуудлыг бэлтгэл хангах, мэргэжил арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газар Б.Баасандоржид үүрэг болгосугай гэсэн ийм 3 заалт бүхий тогтоолын төсөл байна.

Тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Энхтуяа гишүүнийг зөвшөөрсөнд протоколд тэмдэглүүлэе. Ингээд нийтдээ 8 гишүүн санал хураалтад оролцоноос 7 гишүүн дэмжиж, дэлгэц дээр гарсан хувиар бол 75 хувиар тогтоол батлагдлаа.

Ер нь төсөлтэйгөө төлөвлөгөөтэйгөө танилцчихсан тийм ээ, манайхан. Тийм.

Одоо ингээд бид нар 10 дугаар сард өнөөдрийнхөө хурлыг ингээд 15-ны Мягмар гарагт 2 асуудлаа хэлэлцлээ.

22-ны Мягмар гарагт хуралдаж 2 асуудал хэлэлцэнэ. 30-ны Лхагва гарагт хуралдаж 3 асуудал хэлэлцэхээр ингээд энэ сарын төлөвлөгөө гарсан байгаа. Тэгээд дараагийн 11 сарын төлөвлөгөөгөө тухайн үед нь Байнгын хороогоор оруулаад ингээд батлаад явна гэсэн ийм төлөвлөгөөтэй байна.

15.18 цаг

Дээр нь хурлын төгсгөлд мэдээлэл болгоод та бүхэнд нэг зүйл танилцуулахад Ёс зүй, дэгийн байнгын хорооноос Улсын Их Хурлын гишүүн Нарантуяа-Нара-тай холбоотой сахилга хариуцлага тооцсон шийдвэрийг гаргасан.

Гэсэн хэдий боловч Үндсэн хуулийн цэцэд Нарантуяа-Нара гишүүнтэй холбоотой гомдлыг иргэн Номын Баясгалан гэдэг хүн гаргасан. Ингээд

Байнгын хороог төлөөлж, Байнгын хорооны дарга миний бие цэцэд бас холбогдох тайлбаруудыг гаргаж өгсний дагуу 2024 оны 10 сарын 09-ний өдрийн 2/488 дугаарт Үндсэн хуулийн цэцийн албан тоот ирсэн байна. Үүнийг бас мэдээлэл болгоод та бүхэнд танилцуулах нь зөв байх.

Мэдээлэл шилжүүлэх тухай. Иргэн Пүрэвсүрэн, С.Номынбаясгалан нар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандан Улсын Их Хурлын гишүүн Нарантуяа-Нара Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн нэг дэх хэсгийг холбогдох заалтыг зөрчсөн эсэх талаар мэдээлэл ирүүлжээ.

Уг мэдээлэлд дурдсан Улсын Их Хурлын гишүүн Нарантуяа-Нарад холбогдох асуудал нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсгийн холбогдох заалтын дагуу Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарч байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт цэцийн гишүүн шаардлагатай гэж үзвэл өргөдөл мэдээллийг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад шилжүүлж, өргөдөл мэдээллээ гаргагчид энэ тухай мэдэгдэнэ гэж заасны дагуу тус мэдээллийг Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хороонд шийдвэрлэхээр шилжүүлж байна. Түүгээрээ хариу өгнө үү. Хавсралт 9 хуудас гэсэн ийм Болдбаатар гэсэн Үндсэн хуулийн цэцийн гишүүний гарын үсэгтэй ирсэн.

Ер нь бол үүгээр бид энэ мэдээж бас, мэдээж бид энэ парламентынхаа үндсэн дархлааг их бодох ёстой. Улсын Их Хурлын гишүүн хэнд ч байсан гэсэн бас тодорхой түвшиний ёс зүйн дүрэм зөрчсөн ийм агуулга, зүйл, заалтууд бол цаашидаа ч гарахыг үгүйсгэхгүй. Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны гишүүн, Байнгын хороо бол ямар ч

түвшиндээ хуулийг тайлбарлах эрх бол байхгүй. Хуулийг хэрэгжүүлэх, хууль тогтоох үйл ажиллагаанд оролцох эрхтэй ийм байгууллага.

Тэгэхээр бид бол Нарантуяа-Нара гишүүнд бол ямар нэгэн байдлаар Их Хурлын тухай хууль зөрчсөн талаар хариуцлага тооцоогүй. Монгол Улсын Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм зөрчсөн гэдэг агуулгаар бол хариуцлага тооцсон гэдгийг бас протоколд үлдээх нь зөв. Хууль зөрчсөн асуудлыг бол Байнгын хороо тогтоож шийдвэрлэхгүй гэдгийг бол бас энд тэмдэглэн хэлэх нь зөв байх гэж бодож байна.

Ингээд өнөөдрийн. Болохгүй би зүгээр мэдээлэл өгч байгаа тийм. Зүгээр би хэлэлцэх асуудалд ороогүй. Би зүгээр Байнгын хорооны гишүүдээ мэдээлэл өгч байгаа хэлбэр шүү. Тусгайлан хоёулаа уулзаад бол санал хэлж болно.

Ингээд хэлэлцэх асуудал дууслаа.

Хүрэлцэн ирсэн гишүүддээ баярлалаа.

Ингээд дараагийн Байнгын хорооны хурал хүртэл түр баяртай.

Хурал дууслаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ